



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2014 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Өргөдлийн байнгын хорооны 2014 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

Хэлэлцсэн нь:

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар иргэнээс ирүүлсэн өргөдлийн тухай

Шийдвэрлэсэн нь:

1.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь цэргийн тэтгэвэр тогтоолгож буй иргэний хувьд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан шалгуурыг ханган өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүртэл хугацаанд иргэний байгууллагад ажилласан жилээ тооцуулан тэтгэвэр тогтоолгох боломжгүй байгаа нь иргэнд хохиролтой байна гэж үзэх үндэслэлтэй байна.

2.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтыг боловсронгуй болгох талаар судалж Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлөөр хэлэлцэн Байнгын хороонд танилцуулахыг Засгийн газарт чиглэл болгох нь зүйтэй гэж үзэв.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Р.БУРМАА

БАЙНГЫН ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Х.БАТТӨГСӨХ